



ХӨДӨЛМӨРИЙН ЯАМ



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ,
СУДАЛГАА, МЭДЭЭЛЛИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ



ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСЛЫН ШИНЖИЛГЭЭ



Улаанбаатар хот
2015



Хянасан:

Бодлого арга зүйн зөвлөл,
Дэд захирал С.Чойноров

Хэвлэлд бэлтгэсэн:

Ш.Аззаяа Хөдөлмөрийн судалгааны газрын мэргэжилтэн
С.Чулуунцэцэг Хөдөлмөрийн судалгааны газрын ахлах мэргэжилтэн

Боловсруулсан:

Ш.Аззаяа Хөдөлмөрийн судалгааны газрын мэргэжилтэн



ӨМНӨХ ҮГ

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй болон түүнтэй холбогдох харилцаа нь Монгол Улсын “Хөдөлмөрийн тухай”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль”-аар зохицуулагддаг. 2008 онд манай оронд “ХАБЭА-н тухай хууль” батлагдах хүртэл ХАБЭА-н асуудал “Хөдөлмөрийн тухай хууль”-аар зохицуулагдаж ирсэн юм.

Нийгэм, эдийн засгийн орчин тэлж өргөжихийн хэрээр уул уурхай, барилга, эрчим хүч зэрэг эрсдэл өндөртэй салбарууд хөгжих нөхцөл бүрдэж, энэ чиглэлийн ажиллах хүчний тоо зах зээлийн жамаар өсөн нэмэгдсээр байна. Үүнтэй холбоотойгоор хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал сөхөгдөж, Монгол хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах нь ААНБ-уудын нийгмийн хариуцлагын гол асуудал болон хурцаар тавигдаж байгаа юм. ХАБЭА-н түвшин нь үйлдвэрлэлийн болон ажлын байрны олон хүчин зүйлээс бүрдэх бөгөөд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний байдалд дүн шинжилгээ хийх, эрүүл мэнд, амь нас, бие сэтгэлээрээ хохирсон ажиллагчдын нөхөн төлбөрийн асуудлыг судлан шийдвэрлэх, ингэхдээ бусад орны туршлагыг авч үзэх шаардлага урган гарч байна.

Энэхүү шинжилгээний ажилд үйлдвэрлэлийн ослын тохиолдлын тоо, түүнд өртсөн хүмүүсийн мэдээллийг хэд хэдэн үзүүлэлтээр харуулж, нөхөн төлбөрийн олон талт асуудлыг өөр улс орнуудтай харьцуулан шинжлэн дүгнэж, энэ чиглэлийн тогтолцоог илүү боловсронгуй болгох талаар санал, зөвлөмж боловсруулахыг хичээн ажиллалаа. Уг ажилд МХЕГ-ын тоон мэдээлэл, НДЕГ-ын мэдээллийн сан, бусад улс орны статистик үзүүлэлт болон Монгол Улсын “Хөдөлмөрийн тухай” хууль, “Нийгмийн даатгалын сангаас үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр тэтгэмж төлбөрийн тухай” хууль, бусад улс орны хууль, дүрэм энэ чиглэлээр гаргасан судалгаа, тайлан зэрэг эх сурвалжуудыг ашиглав. Нэмж тэмдэглэхэд энэ шинжилгээний ажил үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм болон ХАБЭА-н тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэлэлцүүлэг явагдаж байгаа чухал цаг үетэй давхцан гарч байгаагаараа ач холбогдолтой юм.

Та бүхэнд бидний шинжлэн бэлтгэсэн энэхүү ажилтай холбоотой аливаа санал, зөвлөмж байх аваас Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, судалгаа, мэдээллийн үндэсний төвийн lecom@labornet.gov.mn цахим хаягаар ирүүлнэ үү.

ЗАХИРАЛ

Г.БИЛЭГСАЙХАН



АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ.....	4
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ.....	5
ЗУРГИЙН ЖАГСААЛТ.....	5
ОЙЛГОЛТ ТОДОРХОЙЛОЛТ.....	6
ХУРААНГУЙ.....	8
ТАНИЛЦУУЛГА.....	10
Үндэслэл.....	10
Зорилго.....	10
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСЛЫН ТӨЛӨВ БАЙДАЛ /Монгол улс/.....	11
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСЛЫН НӨХӨН ТӨЛБӨР /Улс орнуудын/.....	22
ДҮГНЭЛТ.....	30
САНАЛ, ЗӨВЛӨМЖ.....	33
АШИГЛАСАН МАТЕРИАЛ.....	34

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

ЗГ	Засгийн Газар
ХАБЭА	Хөдөлмөрийн Аюулгүй Байдал, Эрүүл Ахуй
ҮО	Үйлдвэрлэлийн Осол
МШӨ	Мэргэжлээс Шалтгаалах Өвчин
ХХ	Хурц Хордлого
ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо
ХСИ	Хөдөлмөрийн Судалгааны Институт
ААНБ	Аж Ахуйн Нэгж Байгууллага
ЭЗҮА	Эдийн Засгийн Үйл Ажиллагаа
МХЕГ	Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар
НДЕГ	Нийгмийн Даатгалын Ерөнхий Газар



ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Үйлдвэрлэлийн осолд орсон хүний тоо, салбараар, хүйсээр.....	14
Хүснэгт 2. Үйлдвэрлэлийн ослоос болж амь насаа алдсан хүний тоо, салбараар, оноор.....	18
Хүснэгт 3. Үйлдвэрлэлийн ослын нөхөн төлбөрийн холбогдох үзүүлэлтүүдийг бусад улс орнуудтай харьцуулсан харьцуулалт.....	24
Хүснэгт 4. ҮОМШӨ-ний даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэр авагчид.....	27

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Нийт үйлдвэрлэлийн ослын тоо, оноор.....	12
Зураг 2. Бүлэг ослын тоо, оноор.....	12
Зураг 3. Нийт үйлдвэрлэлийн осолд орсон хүний тоо, хүйсээр.....	13
Зураг 4. Үйлдвэрлэлийн ослын тоо, ЭЗҮА-ны салбарууд, оноор.....	14
Зураг 5. Салбаруудын үйлдвэрлэлийн осолд орсон хүмүүсийн тоо хувиар / 2010 он /.....	16
Зураг 6. Нийт салбаруудын үйлдвэрлэлийн осолд орсон хүмүүсийн тоо, ослын хэлбэр, оноор.....	16
Зураг 7. Ослоос болж амь насаа алдсан хүний тоо, оноор /Япон улс/.....	17
Зураг 8. Үйлдвэрлэлийн ослоос болж амь насаа алдсан хүний тоо, салбараар /2010 он/.....	18
Зураг 9. Нийт салбаруудын ҮО-оос болж тахир дутуу болсон ажиллагчдын тоо, оноор.....	19
Зураг 10. Нийт үйлдвэрлэлийн ослын шалтгаан, оноор.....	19
Зураг 11. Үйлдвэрлэлийн осолд өртөгсдийн тоо, ажилласан жилээр, оноор.....	20
Зураг 12. Үйлдвэрлэлийн осолд өртөгсдийн тоо, насны бүлгээр.....	21
Зураг 13. Барилгын салбарт үйлдвэрлэлийн осолд орсон хүний тоо, насны бүлгээр, оноор.....	21
Зураг 14. Ажилчдын үйлдвэрлэлийн ослын нөхөн төлбөр шинээр авагчдын тоо, оноор /Япон/.....	28



ОЙЛГОЛТ ТОДОРХОЙЛОЛТ

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй

Хөдөлмөрлөх явцад хүний ажиллах чадвар, эрүүл мэндийг хэвээр хадгалах, эрүүл, аюулгүй нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн нийгэм, эдийн засаг, зохион байгуулалт, техник, технологи, ариун цэвэр, эрүүл ахуйн арга хэмжээ авах, эмчлэх, сувилах, нөхөн сэргээх, эрсдэлээс хамгаалах үйл ажиллагааг хэлнэ.

Хөдөлмөрийн аюулгүй байдал

Хөдөлмөрлөх явцад хүний эрүүл мэнд, хөдөлмөрлөх чадварт үйлдвэрлэлийн аюултай, хортой хүчин зүйлийн нөлөөллийн түвшин нь эрүүл ахуйн зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрээгүй байхыг хэлнэ.

Хөдөлмөрийн эрүүл ахуй

Хөдөлмөрлөх явцад хими, физик, биологийн хүчин зүйлээс шалтгаалан хүний бие махбодь, мэдрэл сэтгэхүйд өөрчлөлт орж өвчлөх, хөдөлмөрийн чадвараа түр болон бүрэн алдахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагааг

Хөдөлмөрийн нөхцөл

Хөдөлмөрлөх явцад хүний ажиллах чадвар, эрүүл мэндэд дагнасан буюу хамссан байдлаар нөлөөлөх ажлын байрны болон үйлдвэрлэлийн орчныг хэлдэг.

Үйлдвэрлэлийн хортой хүчин зүйл

Хүний эрүүл мэндэд нөлөөлж өвчлүүлэх, сэтгэхүйд өөрчлөлт оруулах, хөдөлмөрлөх чадварыг бууруулах, мэргэжлийн өвчин бий болгох уршиг бүхий үйлдвэрлэлийн хүчин зүйлийг хэлнэ.

Үйлдвэрлэлийн аюултай хүчин зүйл

Ажлын ээлжийн хугацаанд хурц хордлого, үйлдвэрлэлийн осолд хүргэх, хүний эрүүл мэнд, амь насанд аюул учруулах хүчин зүйлийг хэлнэ.

Хөдөлмөрийн аюулгүй нөхцөл

Ажилтанд нөлөөлөх үйлдвэрлэлийн хортой ба аюултай хүчин зүйлийн нөлөөллийн түвшин нь хөдөлмөрийн аюулгүй байдлын тогтоосон хэм хэмжээнээс хэтрээгүй байхыг хэлнэ.



Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн аюулгүй байдал

Зураг төсөл, техникийн баримт бичигт заасан нөхцлийн дагуу тоног төхөөрөмжийг ажиллуулахад хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны шаардлага хангасан байхыг хэлнэ.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт

Хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар эрх бүхий байгууллагаас тогтоосон хэм хэмжээг хэлнэ.

Үйлдвэрлэлийн осол

Ажилтан ажил олгогчоос өгсөн хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад үйлдвэрлэлийн болон түүнтэй адилтгах аюултай хүчин зүйлийн нөлөөнд өртөж эрүүл мэндээр хохирох, амь насаа алдахыг хэлнэ.

Ажилтай холбогдсон осол

Ажил олгогчоос өгсөн үүрэг даалгавартай шууд холбогдолгүй боловч тухайн ажилтны ажил хөдөлмөртэй ямар нэгэн байдлаар холбогдсон ослыг хэлнэ.

Ахуйн осол

Ажил, хөдөлмөрлөх үүрэгтэй огт холбогдолгүй, ахуйн болон бусад нөхцөлд гарсан ослыг хэлнэ.

Бүлэг осол

Үйлдвэрлэлийн нэг аюултай хүчин зүйлд хоёр, түүнээс дээш хүн өртсөн байвал бүлэг осол гэнэ.

Мэргэжлээс шалтгаалсан өвчин

Хөдөлмөрлөх явцад үйлдвэрлэлийн хортой хүчин зүйлийн нөлөөллөөс шалтгаалан ажилтны бие махбодод үүссэн өвчнийг хэлнэ.

Хордлого

Химийн хорт, цацраг болон биологийн идэвхт бодис зэрэг гадны биет хүний бие махбодод янз бүрийн замаар навтрэн орж сөрөг нөлөө үзүүлэх, өвчлүүлэхийг хэлнэ.

Хурц хордлого

Хурц, цочмог хэлбэрээр богино хугацаанд хордож эрүүл мэндээр хохирох, амь насаа алдахад хүргэдэг.

Архаг хордлого

Бага багаар хордож яваандаа өвчин эмгэг үүсэхэд хүргэдэг.



ХУРААНГУЙ

Шинжилгээний ажлын зорилго нь Монгол Улсын хэмжээнд гарч байгаа үйлдвэрлэлийн ослын тоон мэдээлэлд шинжилгээ хийн, үйлдвэрлэлийн ослын нөхөн төлбөрийн тогтолцоог бусад орнуудтай харьцуулан тодорхойлж, үйдвэрлэлийн ослын нөхөн төлбөрийн тогтолцоог илүү боловсронгуй болгох талаар санал, зөвлөмж боловсруулахад оршино. Бид МХЕГ-ын үйдвэрлэлийн ослын тоон мэдээллийн санд үндэслэн ҮО-ын тоо болон осолд орсон хүмүүсийн тоог олон үзүүлэлтүүдээр задлан харуулж, зарим үзүүлэлтүүдийг Япон улсын статистик тоон мэдээлэлд харьцуулахын сацуу НДЕГ-ын мэдээллийн санг ашигласан бөгөөд ҮО-ын нөхөн төлбөрийн талаарх холбогдох үзүүлэлтүүдийг бусад улс орнуудтай харьцуулан дүгнэлт, санал зөвлөмж боловсрууллаа.

ХАБЭА-н асуудал нь зөвхөн Монгол Улсад төдийгүй дэлхийн нийтэд тулгамдаж буй нийтлэг асуудал юм. ХАБЭА-н түвшин нь олон хүчин зүйлээс хамаарах бөгөөд тэр тусмаа үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний байдалд дүн шинжилгээ хийх, эрүүл мэнд, амь нас, бие сэтгэлээрээ хохирсон ажиллагчдын нөхөн төлбөрийн асуудлыг судлан шийдвэрлэх, бусад орнуудын туршлагыг авч үзэх шаардлага тулгарч байна.

Улсын хэмжээнд нийт үйлдвэрлэлийн ослын тохиолдлын тоог 1986 оноос 2014 он хүртэлх байдлаар харвал буурах хандлагатай байгаа ч сүүлийн дөрвөн жилд өсөх хандлагатай байна. Сүүлийн 10 жилд нийтдээ 4150 үйлдвэрлэлийн осол гарсан байна. Үүнээс бүлэг ослын тоог сүүлийн арван жилийн байдлаар авч үзвэл 2006 онд хамгийн их болсон бөгөөд 2008 оноос хойш буурах хандлагатай байна. Харин 2003-2013 онуудад нийтдээ 3414 эрэгтэй ажиллагчид, 1254 эмэгтэй ажиллагчид / эрэгтэй ажиллагчдаас 2,4 дахин бага/ үйлдвэрлэлийн осолд орсон байна. ЭЗҮА-ы салбараар сүүлийн 7 жилийн байдлаар авч үзэхэд манай улсын хувьд ХАА-н салбарт тохиолдох үйлдвэрлэлийн осолд орсон хүний тоо харьцангуй бага байсан бол уул уурхай, барилга, зам тээврийн салбарын хувьд нэлээн дээгүүр байр суурийг эзэлж байна. Япон улсын хувьд боловсруулах аж үйлдвэр, барилгын салбар дахь үйлдвэрлэлийн осолд орсон хүний тоо өндөр байгаа бөгөөд далайн тээвэр, зам тээвэр, уул уурхайн салбарт бага хувийг эзэлж байна. Үйлдвэрлэлийн ослын шалтгааныг сүүлийн арван жилийн байдлаар харвал дийлэнх онуудад ослын гол шалтгаан уналт, нуралт байсан бол зарим онуудад



бусад шалтгаанууд өндөр хувийг эзлэхээс гадна аюулгүй ажиллах арга барилд хангалтгүй суралцснаас осол гарах үндсэн шалтгаан болж байна. Үйлдвэрлэлийн осолд өртөгсдийг ажлын туршлагаар ангилан авч үзэхдээ сүүлийн 10 жилийн байдлаар харьцуулан харахад 2006 оноос хойш 5 хүртэл жил ажилласан хүмүүс осолд их өртөж нэмэгдэх хандлага ажиглагдсан. Харин эсрэгээрээ ажлын туршлагатай буюу 15-аас дээш жил ажилласан хүмүүс 10 жилийн өмнө осолд өртөх нь давамгайлдаг байсан бол сүүлийн жилүүдэд буурах хандлагатай байна. Мөн 18-35 насны ажиллагчид осолд өртөх нь 2005 оноос хойш давамгайлах хандлага ажиглагдаж байна.

ҮО-ын нөхөн төлбөрийн асуудлыг бусад орнуудтай харьцуулахад Япон, Хятад улсуудын хувьд тогтолцоо зарим талаараа ойролцоо хэдий ч бусад орнуудын нөхөн төлбөрийн хэмжээ, бодох аргачлал, гэмтлийн зэрэг тогтоох зэргээр ялгаатай талууд байна. Харин ослын даатгалын тогтолцооны зохион байгуулалтын хувьд манай улс салангид, бодлогын хувьд нэгдмэл бус тогтолцоотой байгаа бол бусад орнуудын хувьд нэг газар төвлөрсөн нэгдмэл байна. Мөн ҮО-ын нөхөн төлбөрийн төрөл, хэлбэрийн хувьд бусад орнуудтай ойролцоо талууд бий ч зарим орнуудын хувьд ялгаатай уян хатан сайшаалтай талууд байна. ҮО-ын нөхөн төлбөрийг нэхэмжлэх, гомдол барагдуулах хугацаа улс орон бүрт харилцан адилгүй өөр өөр байна.



ТАНИЛЦУУЛГА

Үндэслэл

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй нь үйлдвэрлэл, үйлчилгээний явцад техник, технологийн үйл ажиллагаанаас шалтгаалан ажилтны эрүүл мэндэд хими, физик, биологийн болон бие сэтгэхүйд өөрчлөлт орж хөдөлмөрийн чадвар буурах, өвчлөх, осолд орохоос урьдчилан сэргийлэхэд чиглэсэн нийгэм, эдийн засаг, техник технологи, зохион байгуулалтын арга хэмжээний цогц юм. Монгол Улсын “Хөдөлмөрийн тухай”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль”-аар хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн харилцааг зохицуулж байна. Монгол Улсад Уул уурхай, барилга, эрчим хүч зэрэг эрсдэл өндөртэй салбарууд хөгжих нөхцөл бүрдэж байгаатай холбоотой энэ салбарт ажиллах хүч өргөн хүрээтэйгээр нэмэгдэж байгаа өнөө үед хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал монгол хүний амь нас, эрүүл мэндтэй холбоотой ААНБ-уудын нийгмийн хариуцлагын гол асуудал болж хурцаар тавигдаж байна. Түүнчлэн зөвхөн ажил олгогч төдийгүй ажилтны ажилдаа хандах итгэл, сэтгэл, тухайн ажилтнуудын ур чадвар, мэдлэг, сахилга дэг журам, ажлын байрны соёл хандлага зэрэг нь ажлын байранд аюулгүй ажиллах гол шалгуур болж байна. ХАБЭА-н түвшин нь үйлдвэрлэлийн болон ажлын байрны эрүүл ахуйн нөхцөл, зохион байгуулалт, мэргэжлийн сургалтын чанар, ашиглаж байгаа техник, технологийн шинж чанар, ажилтны сэтгэл зүй физиологийн онцлог зэрэг олон хүчин зүйлээс хамаарах бөгөөд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний байдалд дүн шинжилгээ хийх, эрүүл мэнд, амь нас, бие сэтгэлээрээ хохирсон ажиллагчдын нөхөн төлбөрийн асуудлыг судлан шийдвэрлэх, бусад орнуудын туршлагыг авч үзэх шаардлага тулгарч байна.

Зорилго

Монгол Улсын хэмжээнд гарч байгаа үйлдвэрлэлийн ослын тоон мэдээлэлд шинжилгээ хийн, үйлдвэрлэлийн ослын нөхөн төлбөрийн тогтолцоог бусад орнуудтай харьцуулан шинжилж, үйдвэрлэлийн ослын нөхөн төлбөрийн тогтолцоог илүү боловсронгуй болгох талаар санал, зөвлөмж боловсруулахад оршино.



ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСЛЫН ТӨЛӨВ БАЙДАЛ /Монгол Улс/


Монгол Улсад хөдөлмөрийн харилцааг зохицуулах хууль, тогтоомж анх бүрэлдэн тогтсон тэр үеэс хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал албан ёсоор тавигдаж хөгжиж эхэлжээ. 2008 онд ХАБЭА-н тухай хууль батлагдан мөрдөгдөх хүртэл ХАБЭА-н асуудлыг хөдөлмөрийн хуулиар зохицуулсаар ирсэн билээ. 1940-1990 он нь хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал, эрүүл ахуйн салбарын хөгжлийн чухал үе байсан бөгөөд цаашдын хөгжил дэвшлийн суурь нь болсон юм. Ерэн он гарсаар манай орон төдийгүй дэлхий дахины ХАБЭА-н салбар өөрчлөгдөн шинэчлэгдэж олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах хамтын ажиллагаа өргөжин тэлсэн билээ. ХАБЭА-н асуудал нь хамтын гэрээ, хамтын хэлэлцээрээр зохицуулах чухал харилцааны нэг бөгөөд “Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийн судалгаа”, “Хамтын гэрээ, хамтын хэлэлцээрийн төлөв байдал, хэрэгжилтийн судалгаа”, “Нүүрсний салбарын ХАБЭА-н төлөв байдлын судалгаа” зэрэг ХСИ-ээс (хуучнаар) хийгдсэн судалгааны үр дүнгүүдээс ХАБЭА-н асуудалд ажил олгогч ямар ач холбогдол өгдөг талаар харж болно.

Үйлдвэрлэлийн, байгалийн болон бусад ямар нэгэн аюултай хүчин зүйлийн нөлөөнд өртөж гэмтэх, эрүүл мэндээр хохирохыг осол гэнэ. Осол ямар нөхцөл байдалд гарснаас хамаарч үйлдвэрлэлийн, ажилтай холбогдсон, ахуйн осол гэж ангилдаг. Сүүлийн жилүүдэд хүнд үйлдвэр, геологи, уул уурхай, барилга, зам тээвэр, эрчим хүчний салбарууд эрчимтэй цэцэглэн хөгжихийн хирээр тухайн салбаруудад ажиллах ажиллагчдын тоо ихэсч үүнтэй холбоотойгоор ХАБЭА-н асуудал тэр дундаа үйлдвэрлэлийн ослын асуудал хурцаар тавигдаж байна.

Бид энэхүү бүлэгт Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын мэдээллийн сан болон бусад улсын статистик мэдээллийг ашиглалаа.



Зураг 1. Нийт үйлдвэрлэлийн ослын тоо, оноор (Хэмжих нэгж: Тоо)



Нийт үйлдвэрлэлийн ослын тохиолдлын тоог 1986 оноос 2014 он хүртэлх байдлаар харвал ерөнхийдөө буурах хандлагатай байгаа ч сүүлийн дөрвөн жилд тогтвортой өсөх хандлага руу чиглэсэн байна. 1996, 2008 онуудад үйлдвэрлэлийн осол хамгийн их тохиолдож байсан бол 2009, 2010 онуудад харьцангуй бага байгааг харж болно. Сүүлийн 10 жилд нийтдээ 4150 үйлдвэрлэлийн осол гарсан байна.

Үүнээс бүлэг ослын тоог сүүлийн арван жилийн байдлаар авч үзвэл /Зураг 2/ 2006 онд хамгийн их бүлэг осол болсон бөгөөд 2008 оноос хойш буурах хандлагатай байна.

Зураг 2. Бүлэг ослын тоо, оноор (Хэмжих нэгж: Тоо)





Зураг 3. Нийт үйлдвэрлэлийн осолд орсон хүний тоо, хүйсээр
(Хэмжих нэгж: Тоо)



Сүүлийн 10 жилийн үйлдвэрлэлийн ослын тохиолдлын тоог осолд өртсөн ажиллагчдын хүйсээр авч үзвэл үйлдвэрлэлийн осолд эрэгтэй ажиллагчид илүү өртсөн байна. Энэ нь “Жендэрийн шинжилгээ”-нд дурьдсанчлан нийт ажиллагчдад эрэгтэй ажиллагчдын эзлэх хувь өндөр байгаатай холбон үзэж болох юм. Ялангуяа уул уурхай, барилга, эрчим хүчний салбарт осол илүүтэй гарч байгааг тухайн салбаруудад эрэгтэй ажиллагчид илүү өндөр хувьтай ажиллаж байгаатай холбон тайлбарлаж болох юм. 2003 онд үйлдвэрлэлийн осолд зөвхөн эрэгтэй ажиллагчид өртсөн байгааг онцлон харж болохоор байна. Харин эмэгтэй ажиллагчдын хувьд хэдийгээр эрчүүдээс осолд бага өртсөн байгаа боловч 2013 онд эмэгтэйчүүд үйлдвэрлэлийн осолд хамгийн ихээр өртжээ. Энэ нь ослын бүртгэл, мэдээлэлтэй холбоотой байж болох юм. Харин 2003-2013 онуудад нийтдээ 3414 эрэгтэй ажиллагчид, 1254 эмэгтэй ажиллагчид /эрэгтэй ажиллагчдаас 2,4 дахин бага/ үйлдвэрлэлийн осолд орсон байна.



Зураг 4. Үйлдвэрлэлийн ослын тоо, ЭЗҮА-ны салбарууд, оноор
(Хэмжих нэгж: Тоо)



Үйлдвэрлэлийн ослын тохиолдлын тоог сүүлийн долоон жилийн байдлаар салбараар авч үзэхэд харилцан адилгүй байна. ХАА-н салбарт тохиолдох үйлдвэрлэлийн ослын тоо харьцангуй бага байдаг бол уул уурхай, барилгын салбарын хувьд ослын тоо давамгайлж байгаа нь харагдаж байна. 2012-2014 онуудад уул уурхайн салбарт нийт 202, барилгын салбарт 173 үйлдвэрлэлийн осол бүртгэгджээ. Зөвхөн 2012 оны хувьд авч үзвэл уул уурхайн салбарын ажиллагчдын тоо барилгын салбарын ажиллагчдын тооноос 12,5 мянгаар бага байгаа боловч тухайн салбарт нийт ажиллагчдад эзлэх үйлдвэрлэлийн ослын хувь нь 0,16% буюу барилгын салбарын тухайн үзүүлэлтээс 0,05%-аар өндөр байна.

Хүснэгт 1. Үйлдвэрлэлийн осолд орсон хүний тоо, салбараар, хүйсээр

Салбар	Хүйс	Он					
		2008	2009	2010	2011	2012	2013
Эрчим хүч	Эр	27	16	21	23	13	24
	Эм	3	1	1	2	1	1
Уул уурхай	Эр	116	77	89	75	89	54
	Эм	7	4	9	5	2	10
Хөдөө аж ахуй	Эр	2	0	1	1	1	9
	Эм	0	2	1	2	0	3



Барилга	Эр	126	51	47	64	65	36
	Эм	23	4	5	8	7	5
Хөнгөн хүнс	Эр	41	25	16	19	16	15
	Эм	23	7	15	10	10	17
Зам тээвэр холбоо	Эр	43	26	25	43	22	30
	Эм	14	28	8	8	13	19
Худалдаа үйлчилгээ	Эр	34	7	12	5	13	14
	Эм	13	5	3	11	5	5
Боловсрол	Эр	18	31	11	17	14	9
	Эм	19	14	10	21	16	39
Эрүүл мэнд	Эр	11	7	24	12	18	8
	Эм	21	18	17	16	20	25
Бусад	Эр	102	66	60	61	62	55
	Эм	28	21	23	29	37	47

2008-2013 онуудад гарсан үйлдвэрлэлийн ослын тохиолдлын тоог салбар, хүйсээр ангилан харвал ихэвчлэн эрэгтэй ажилтан үйлдвэрлэлийн осолд өртөх нь элбэг байсан бол эрүүл мэнд, боловсролын салбарт эмэгтэй ажилтан илүүтэй үйлдвэрлэлийн осолд өртсөн байна. Энэ нь тус салбаруудад эмэгтэй ажиллагчдын тоо өндөр байгаатай холбоотой юм.

Зураг 5-д 2010 онд нийт үйлдвэрлэлийн осолд орсон хүмүүсийн тоог салбаруудаар /эзлэх хувь/ Монгол, Япон улсыг харьцуулан гаргалаа. 2 улсын эдийн засгийн үйл ажиллагааны салбаруудын ангилал өөр өөр учраас ижил төсөөтэй харьцуулахуйц болгохын тулд Монгол улсын зарим салбаруудыг багцлан ангилсан гэдгийг энд хэлэх хэрэгтэй.

Япон улсын хөдөлмөр эрхэлж байгаа хүн амд үйлдвэрлэлийн осолд өртсөн хүмүүсийн тоог харьцуулахад 0,18%-ийг эзэлж байгаа бол Монгол улсын хувьд 0,04% байна. Мөн Солонгос улсын хувьд 2014 оны байдлаар тухайн жилд нийт 90,909 хүн осолд орсон бөгөөд нийт хөдөлмөр эрхэлж байгаа хүний тоонд харьцуулахад 0,53% байгаа нь нэлээн өндөр үзүүлэлт юм. Энэ нь ослыг мэдээлэх, бүртгэх нь хангалтгүй байгаатай холбож болох юм.

Харин салбараар авч үзвэл манай улсын хувьд нийт осолд орсон хүмүүсийн ихэнх хувийг уул уурхайн салбарын үйлдвэрлэлийн осолд орсон хүний тоо эзэлж байгаа бол Япон улсын хувьд эсрэгээрээ уул уурхайн салбар хамгийн бага хувийг эзэлж байгаа бол боловсруулах аж үйлдвэрийн салбарт үйлдвэрлэлийн осолд орсон хүмүүсийн эзлэх




хувь өндөр байна. Энэ нь 2 улсын эдийн засгийн онцлогтой холбоотой. Барилгын салбарын хувьд үйлдвэрлэлийн осолд орсон хүний эзлэх хувь хоёр улсын хувьд ойролцоо байна. Монгол, Япон улсад бусад гэсэн ангилалын салбаруудад үйлдвэрлэлийн осолд орсон хүмүүсийн хувь өндөр байгаа нь ойролцоо байна. Бусад салбаруудад боловсрол, эрүүл мэнд, хөнгөн хүнс зэрэг үйлчилгээний салбаруудыг багтаадаг.

Зураг 5. Салбаруудын үйлдвэрлэлийн осолд орсон хүмүүсийн тоо хувиар /2010 он/




Зураг 6. Нийт салбаруудын үйлдвэрлэлийн осолд орсон хүмүүсийн тоо, ослын хэлбэр, оноор (Хэмжих нэгж: Тоо)



Дээрх зургаас үйлдвэрлэлийн осолд орсон хүмүүсийг ослын хэлбэрүүдээр болон оноор харвал харилцан адилгүй байгаа ба хөнгөн хэлбэрийн осолд орсон хүний тоо 2003-2005, 2010-2012 онуудад, хүнд хэлбэрийн осолд орсон хүний тоо 2006-2009, 2013 онуудад нийт ослын дийлэнхийг эзэлж байна. Харамсалтай нь 2008 онд нийт осол дахь амь насаа алдсан хүний тоо өндөр байна. 2008 оноос хойш буурах хандлагатай байгаа ч дорвитой багасахгүй байна. Сүүлийн 10 жилд нийт 913 хүн үйлдвэрлэлийн ослоос болж амь насаа алдсан байна.



Зураг 7. Ослоос болж амь насаа алдсан хүний тоо, оноор /Япон улс/
(Хэмжих нэгж: Тоо)



■ Амь насаа алдсан хүний тоо

Япон Улсын бүх салбарт гарсан үйлдвэрлэлийн ослоос болж амь насаа алдсан хүний тоог сүүлийн 21 жилийн байдлаар Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн аюулгүй байдлын хэлтсийн судалгаагаар гаргасан байна. Эндээс ослын байдал буурах хандлагатай байгаа нь ажиглагдаж байна. Харин манай улстай харьцуулан харвал Японд амь үрэгдсэн хүний тоо маш их байгаа ба нийт хүн ам болон хөдөлмөр эрхэлж буй хүн амын тоо манай орноос хэд дахин их учраас тооны хувьд харьцуулахад өрөөсгөл юм. Харин Монгол Улсын нийт хөдөлмөр эрхэлж буй хүн амын тоонд амь үрэгдсэн хүмүүсийн тоог харьцуулвал 0,008% байгаа бол Япон улсын хувьд 0,002% байна. Энэ нь Монгол Улс нийт амь үрэгдсэн хүмүүсийн тоогоор маш бага харагдаж байгаа хэдий ч хөдөлмөр эрхэлж буй хүмүүст харьцуулбал Япон Улсаас бага зэрэг өндөр байна. Мөн Японд ослын тоо буурах хандлагатай байгаа ба манай улсын хувьд хэлбэлзэлтэй буюу 2013 онд амь насаа алдсан хүний тоо 10 жилийн өмнөх ослын тоотой адил түвшинд байна.




Хүснэгт 2. Үйлдвэрлэлийн ослоос болж амь насаа алдсан хүний тоо, салбараар, оноор (Хэмжих нэгж: Тоо)

Салбар	Он /амь насаа алдсан хүний тоо					
	2008	2009	2010	2011	2012	2013
Эрчим хүч	5	1	5	3	4	3
Уул уурхай	42	23	18	31	33	14
Хөдөө аж ахуй	0	0	1	2	0	0
Барилга	63	12	21	25	28	14
Хөнгөн хүнс	9	1	4	0	1	1
Зам, тээвэр, холбоо	13	2	6	5	2	8
Худалдаа үйлчилгээ	6	2	5	0	0	1
Боловсрол	3	3	1	1	2	2
Эрүүл мэнд	5	0	6	1	2	3
Бусад	16	10	13	7	15	5
Нийт	162	54	80	75	87	51

Үйлдвэрлэлийн ослоос болж амь насаа алдсан ажиллагчдыг салбараар, оноор харьцуулан харвал 2008 онд хамгийн их осол гарсан байдаг. Тэр дундаа барилга, уул уурхайн салбарт хамгийн их осол гарсан ба бусад онуудад ч мөн адил тус салбаруудад ослын тоо өндөр байна. Энэ нь барилга, уул уурхайн салбарын эдийн засгийн үйл ажиллагаа эрчимтэй хөгжиж буй манай улсын хувьд маш таагүй үзүүлэлт бөгөөд уг салбаруудын ХАБЭА-н асуудал нэн тулгамдаж байгааг батлан харуулж байна.

Зураг 8. Үйлдвэрлэлийн ослоос болж амь насаа алдсан хүний тоо, салбараар /2010 он/ (Хэмжих нэгж: Тоо)



Дээрх зурагт 2010 онд гарсан үйлдвэрлэлийн ослоос болж нийт амь




насаа алдсан хүний тоог салбаруудаар Монгол, Япон 2 улсыг харьцуулан харууллаа. Үүнээс харахад манай улсын хувьд барилга, уул уурхайн болон бусад салбаруудын амь насаа алдсан хүний эзлэх хувь өндөр байгаа ба Япон Улсад ХАБЭА-н хэлстийн судалгаагаар бусад салбарууд, барилга, боловсруулах аж үйлдвэрийн салбарын амь үрэгдсэн хүний тоо өндөр хувийг эзэлж байна.

Зураг 9. Нийт салбаруудын ҮО-оос болж тахир дутуу болсон ажиллагчдын тоо, оноор (Хэмжих нэгж: Тоо)



Нийт салбаруудын хувьд үйлдвэрлэлийн ослоос болж тахир дутуу болсон ажиллагчдын тоог 2008-2013 он хүртэлх байдлаар авч үзвэл нийт 501 ажиллагчид ба 2008 оноос хойш буурах хандлагатай байсан ч 2013 онд хамгийн их тооны ажиллагчид тахир дутуу болж бие махбодь, сэтгэл санааны хохирол амссан байна.


Зураг 10. Нийт үйлдвэрлэлийн ослын шалтгаан, оноор (Хэмжих нэгж: Хувь)





Үйлдвэрлэлийн ослын шалтгааныг сүүлийн арван жилийн байдлаар харвал 2004, 2006, 2008-2010 онуудад ослын гол шалтгаан уналт, нуралт байсан бол зарим онуудад бусад шалтгаанууд өндөр хувийг эзлэхээс гадна аюулгүй ажиллах арга барилд хангалтгүй суралцсанаас осол гарах үндсэн шалтгаан болж байна.


Зураг 11. Үйлдвэрлэлийн осолд өртөгсдийн тоо, ажилласан жилээр, оноор (Хэмжих нэгж: Тоо)



Үйлдвэрлэлийн осолд өртөгсдийг ажлын туршлагаар ангилан авч үзэхдээ сүүлийн 10 жилийн байдлаар харьцуулахад 2004, 2005 онд 5 хүртэл жил ажилласан хүмүүс осолд бага өртөж байсан бол 2006 оноос хойш нэмэгдэх хандлага ажиглагдаж байна. Үүнийг тухайн байгууллагад бага хугацаанд ажилласан, тухайн ажил мэргэжилдээ дадлагажаагүй ажлын туршлага бага хүмүүс дийлэнхдээ осолд өртөж байгаатай холбон тайлбарлаж болох юм. Харин эсрэгээрээ ажлын туршлагатай олон жил ажилласан хүмүүс 10 жилийн өмнө осолд өртөх нь их байсан бол сүүлийн жилүүдэд буурах хандлагатай байна.




Зураг 12. Үйлдвэрлэлийн осолд өртөгсдийн тоо, насны бүлгээр (Хэмжих нэгж: Тоо)



Үйлдвэрлэлийн осолд өртөгсдийг насны бүлгээр авч үзэхдээ сүүлийн 10 жилээр харьцуулан гаргасныг дээрх зурагт үзүүлээ. Үүнээс харахад осолд өртсөн ажиллагчдын 18 хүртэлх насны ажиллагчид бага өртсөн байгаа нь харагдаж байна. Энэ нь 18 нас хүртэлх насны ажиллагчид нийт ажиллагчдын дотор эзлэх хувь бага байгаатай холбож болох юм. Харин 18-35 насны ажиллагчид осолд өртөх нь 2003, 2004 онуудад бага байсан ба 2005 оноос хойш нэмэгдэх хандлагатай байна.

Зураг 13. Барилгын салбарт үйлдвэрлэлийн осолд орсон хүний тоо, насны бүлгээр, оноор (Хэмжих нэгж: Тоо)



Үйлдвэрлэлийн осолд орсон хүмүүсийг насны бүлгээр авч үзэхдээ барилгын салбарыг онцлон хархад осолд өртөгсдийн дийлэнхийг 18-35 насны хүмүүс эзэлж байна.



ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСЛЫН НӨХӨН ТӨЛБӨР /Улс орнуудын/

Зах зээл, ардчилсан хөгжлийн замыг сонгосон ихэнх улс орнууд осол өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилтыг нэн тэргүүнд тавьж, эрсдэл гарсан үед даатгуулагчийнхаа хөдөлмөрийн чадварыг хамгийн богино хугацаанд нөхөн сэргээж ажилд нь оруулахыг үйл ажиллагааны үндсэн зарчим болгодог. Уг зарчим нь хөдөлмөрийн үндэсний бодлоготой нягт уялдсан, даатгуулагчийнхаа сэтгэл ханамжид нийцсэн даатгалын чанартай бүтээгдэхүүн, мэргэшсэн үйлчилгээ, тусламж үзүүлэх чадавхи, үйл ажиллагаа, санхүү нь даатгуулагчиддаа ил тод, нээлттэй, тэдний хараа, хяналтад байдаг, бүх түвшиндээ тайлагнадаг, төрөөс иргэнээ хамгаалах бодлогын хүрээнд хамтран ажилладаг, харилцан хүлээх үүрэг хариуцлагын тогтолцоотой, өөрийгөө санхүүжүүлэхэд оршиж байна.

Манай улсын хувьд “Хөдөлмөрийн тухай”, “Нийгмийн даатгалын сангаас үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр тэтгэмж төлбөрийн тухай” зэрэг хуулиудаар ҮО-ын нөхөн төлбөр, түүнтэй холбогдох харилцааг зохицуулдаг байна.

1995 оноос мөрдөгдөж эхэлсэн “Нийгмийн даатгалын сангаас үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр тэтгэмж төлбөрийн тухай” хуульд заасны дагуу ҮО, МШӨ-ий даатгалд даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж тогтоож олгох, төлбөр өгөхтэй холбогдсон харилцааг зохицуулдаг байна. 2015-2016 оны Хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хэлэлцээрт тус хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаар тусгасан бөгөөд энэ хүрээнд осол, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, осол өвчлөлд өртсөн хүмүүст нөхөн сэргээлт хийх, хохиролыг барагдуулах чиглэлээр даатгуулагчдад үзүүлэх тусламж үйлчилгээ, даатгалын бүтээгдэхүүнийг оновчтой, чанартай болгох, энэ чиглэлүүдээр даатгалын байгууллагын чиг үүрэг, удирдлага, санхүүжилтийн зарчмыг тодорхой болгох зэрэг асуудлуудыг авч үзэх нь зүйтэй гэж үзсэн байна.

“Хөдөлмөрийн тухай хууль”-ийн 97 дугаар зүйлд үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөр өвчилсөн ажилтан болон эдгээр шалтгаанаар нас барсан ажилтны ар гэрт учирсан хохирлыг нөхөх зорилгоор ҮО, МШӨ-ий даатгалд даатгуулсан эсэхийг үл харгалзан ажил олгогч нь зохих хэмжээний нөхөн төлбөрийг олгохоор заасан байдаг ба нөхөн төлбөр олгох нь хохирогч нийгмийн даатгалын



болон бусад хууль тогтоомжийн дагуу тэтгэвэр, тэтгэмж авахад нөлөөлөхгүй.

Улс орон бүр өөрийн эдийн засгийн онцлог, хууль эрх зүйн орчин, тогтолцооноос хамаарч нөхөн төлбөрийн асуудлыг хууль тогтоомждоо янз бүрээр тусгасан байдаг. Манай улсын хувьд нөхөн төлбөрийн эх үүсвэр нь Ажил олгогчийн төлөх шимтгэл /даатгуулагчаас/, ААНБ-аас /даатгуулсан эсэхийг үл харгалзан ажил олгогчоос / өгөх нөхөн төлбөрөөс бүрдэж байна. Энэ нь зарим орны үйлдвэрлэлийн ослын нөхөн төлбөрийн үндсэн тогтолцоотой ойролцоо байна. Энэ бүлэгт бусад улс орнуудын үйлдвэрлэлийн ослын нөхөн төлбөрийн буюу даатгалын тогтолцоо, хууль эрх зүйн орчин, үйл ажиллагаа, ослын даатгалын арга хэлбэр, тэтгэмжийн хэмжээ зэргийг өөрийн орны тогтолцоотой харьцуулахыг зорьлоо.



Хүснэгт 3. Үйлдвэрлэлийн ослын нөхөн төлбөрийн холбогдох үзүүлэлтүүдийг бусад улс орнуудтай харьцуулсан харьцуулалт

№	Харьцуулах үзүүлэлтүүд	Монгол	Хятад	Япон	Солонгос	Англи	Австрали
1	Хууль эрх зүйн систем / зохицуулагдах хуулиуд/	- Хөдөлмөрийн тухай хууль - ХАБЭАН-н тухай хууль /2008/ - Нийгмийн даатгалын сангаас олгох ҮО,МШӨ-ий тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль	- Мэргэжлийн ослын даатгалын тухай хууль - Хөдөлмөрийн тухай хууль - Ажил мэргэжлийн өвчнөөс урьцчилан сэргийлэх эмчлэх тухай хууль	- Хөдөлмөрийн хууль - Х ө д ө л м ө р и й н стандартын тухай хууль /1947/ - Ажилчдын ослын нөхөн олгоорын тухай хууль	- Үйлдвэрлэлийн ослын нөхөн олговорын тухай хууль /1953/ - Х ө д ө л м ө р и й н стандартын тухай хууль /1953/ - Үйлдвэрлэлийн ослын даатгалын тухай хууль / IAS/	- Нийгмийн хамгааллын акт /1998/ - Нийгмийн хамгааллын нөхөн төлбөр болон олгох тухай акт /1992/ - Нийгмийн хамгааллын зохицуулалтын тухай акт /1992/	- Ажилчдын нөхөн төлбөрийн акт /1987/ - Ажлын байран дахь гэмтлийн менежмент - Ажилчдын нөхөн төлбөрийн акт /1998/
2	Ослын нөхөн төлбөрийн үндсэн үйл ажиллагааны зохион байгуулалт	Салангид, борлогын хувьд нэгдмэл бус /лус тусдаа чиглэлийн яамдад/	Нэг газар төвлөрсөн.	Нэг газар төвлөрсөн.	Нэг газар төвлөрсөн.	Нэг газар төвлөрсөн.	Нэгдмэл удирдлагаар хангадаг.
3	Нөхөн төлбөрийн нэршил	ҮО, МШӨ-ий тэтгэвэр тэтгэмж	Ажил мэргэжлийн ослын даатгал	Хөдөлмөрийн ослын нөхөн төлбөр	Үйлдвэрлэлийн ослын даатгал	Үйлдвэрийн ослын системийн нөхөн олговор	Ажилчны нөхөн олговор
4	Ослын даатгалын хэлбэр	- Албан журмын - Сайн дурын	- Албан журмын /ажил олгогч дангаараа даатгуулах ёстой/ Хөдөлмөрийн хувь	- Албан журмын /ажил олгогч дангаараа даатгуулах ёстой/ Хөдөлмөрийн ослын нөхөн төлбөр	- Албан журмын Хөдөлмөрийн ослын нөхөн төлбөр	- Албан журмын /үндэсний даатгалд заавал даатгуулах ёстой/ Гэмтлийн эсрэгээр	- Албан журмын даатгалын компани/ Гэмтлийн хэмжээ
5	Нөхөн төлбөр тогтоох аргачлал /үндэслэл /	Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээгээр хөдөлмөрийн хөлсний болон түүнтэй адилтгах хэмжээний орлогоор нөхөн төлбөрийг олгоно.	Нөхөн төлбөрийн хувь нь салбар бүр дээр тэдгээрийн эрсдийн хэмжээнээс хамаарна.	Хөдөлмөрийн ослын нөхөн төлбөр 3 сарын ажилчны сүлгийн дундажийг тохирох өдөрүүдэд үржүүлэн тогтоно.	Үйлдвэрлэлийн ослын нөхөн төлбөрийг тухайн ажилчны дундаж цалинд үндэслэн тооцож олгоно. Үйлдвэрлэлийн ослын 14 төрлийн зэрэглэл байдаг. /Салбар бүрт өөр өөр/	Гэмтлийн эсрэгээр хувь тогтоон тохирох нөхөн төлбөрийг олгоно /эдийн засгийн үйл ажиллагааны тохирох нөхөн төлбөрийг олгоно.	Хэмжээ заргас хамаарч дундаж цалингаас хувь тогтоон тохирох нөхөн төлбөрийг олгоно.
6	Нөхөн төлбөр /тэтгэмж/- хяналт тавьдаг байгууллага	- МХЕГ - Хөдөлмөрийн Яам - Үндэсний хороо/ - Эмнэлэг, хөдөлмөрийн Магдалах комисс - Хөдөлмөрийн эрүүл мэнд судлалын төв	Нийгмийн хамгаалал яам, хяналт шалгалтын газар хэрэгжүүлэгч агентлаг	Хөдөлмөрийн стандарт хяналт шалгалтын газар	Хөдөлмөр нийгмийн халамжийн газар	Барнслигийн /Үйлдвэрийн ослын нөхөн төлбөрийн төв	"Workcover NSW" ² байгууллага

¹ Англи улсын үйлдвэрлэлийн ослын нөхөн төлбөрийн үндэсний төв байгууллага - www.gov.uk

² Австрали улсын үйлдвэрлэлийн ослын нөхөн төлбөрийн төв байгууллага - www.fom.as.nz/wp-content/uploads/mobrepsti.doc



7	Осолд өртөгсөд хаана хандах вэ	Тухайн ААНБ-ын аюулгүй байдалын комисс /абоан бус орон тооны/ МХЕГ Харьяа дүргийн эрүүл мэндийн нэгдэл	Хэрэгжүүлэгч агентлагт	Тухайн ААНБ Улсын эмнэлэг/хувийн эмнэлэг/ Хөдөлмөрийн хэлтсүүд Хөдөлмөрийн стандарт хяналт шалгалтын газар	Хөдөлмөр нийлгийн халамжийн газарт	Барнспегийн Үйлдвэрийн ослын нөхөн төлбөрийн төвд	"Workcover NSW" байгууллагад
8	Нөхөн төлбөрийн эх үүсвэр	Ажил олгогчийн төлөх шимтгэл/даатгуулагчаас/ ААНБ-аас /даатгуулсан эхний үл харгалзан ажил олгогчоос/	Ажил олгогчийн төлөх хураамж /даатгуулагчаас/	Ажил олгогчийн төлөх хураамж /даатгуулагчаас/ -Эг-ын хөрөнгө/ялг -Эг-ын хөрөнгө	Ажил олгогчийн төлөх хураамж /даатгуулагчаас/ -Эг-ын хөрөнгө	Ажил олгогчийн төлөх хураамж /даатгуулагчаас/	Ажил олгогчийн төлөх хураамж /даатгуулагчаас/
9	Даатгуулснаар авах тэтгэвэр, тэтгэмжүүд	Тахир дутуугийн тэтгэвэр - Тэхээгчээ алдсаны тэтгэвэр - Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж - Хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр - Тэтгэврийн даатгалын шимтгэл - ҮО, МШБ-өөс урьдчилан сэргийлэх хэмжээний зардал - Д а т г у л а г ч и й г О р й л а х а ц н о г д о х т у с л а м ж ү й л ч и л г э э н и й х у вь с а х з а р д а л з э р г и й г авах эрхтэй	Хэрэгжүүлэгч агентлагт	Тухайн ААНБ Улсын эмнэлэг/хувийн эмнэлэг/ Хөдөлмөрийн хэлтсүүд Хөдөлмөрийн стандарт хяналт шалгалтын газар	Хөдөлмөр нийлгийн халамжийн газарт	Барнспегийн Үйлдвэрийн ослын нөхөн төлбөрийн төвд	"Workcover NSW" байгууллагад
10	Нэхэмжлэл гаргах хугацаа	Даатгуулагч тахир дутуу болсон, нас барснаас олох шийтгэл 14 хоногийн, хэрэв хүндэтгэх шалтгаантай байсан бол 3 сарын дотор	Хэрэгжүүлэгч агентлагт	Тухайн ААНБ Улсын эмнэлэг/хувийн эмнэлэг/ Хөдөлмөрийн хэлтсүүд Хөдөлмөрийн стандарт хяналт шалгалтын газар	Хөдөлмөр нийлгийн халамжийн газарт	Барнспегийн Үйлдвэрийн ослын нөхөн төлбөрийн төвд	"Workcover NSW" байгууллагад



11	Гомдол барагдуулах хугацаа	Нийлмийн даатгалын тэтгэвэр хөдөлгөөн, бичгийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор шийдвэрлэнэ.	Хэрэгжүүлэгч хөдөлгөөн, бичгийг хүлээж авснаас 30-90 хоногийн дотор шийдвэрлэнэ.	Гэмтлийн зэргээс буюу хүнд хөнгөнөс шалтгаалж 30-90 хоногийн дотор шийдвэрлэнэ.	Холбогдох байгууллага мэдэгдэл хүлээн авснаас 7 хоногийн дотор шийдвэрлэнэ.	Холбогдох байгууллага мэдэгдэл хүлээн авснаас 7 хоногийн дотор шийдвэрлэнэ.
12	Тэтгэмжийн дээд хэмжээ	Нийлмийн даатгалын тэтгэвэр хөдөлгөөн, бичгийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор шийдвэрлэнэ. -Хөдөлмөрийн чадвараа 30, түүнээс дээш хувийг ашиглаж турдуу болсон бол ЗГ-аас тогтоосон ХХД-ий 75 хувийг олгоно. -Хөдөлмөрийн чадвараа 71 хувийг авсан ажилтанд 18 сарын цалингийн дундажтай тэнцэх хэмжээний нөхөн төлбөрийг нэг ба түүнээс дээш удаа олгоно.	7 хоногийн цалинг /үлсын дундаж/ 300% өдрөөр /гэмтлийн зэрэг/ болж олгоно. -3,420,000 ленийг ЗГ-аас /нэг удаагийн мөнгөн тэтгэмж/	Сүүлийн 3 сарын цалингийн дундажийг 503 өдрөөр /гэмтлийн зэрэг/ болж олгоно. -3,420,000 ленийг ЗГ-аас /нэг удаагийн мөнгөн тэтгэмж/	Тухайн ажилчны дундаж цалинд үндэслэн тоолох олгоцоо салбар болон даатгалын төрлөөс янз бүр шалтгаалж тогтоогдог.	Гэмтлийн зэрэг 95-100% бол хөдөлмөрийн хөдөлгөөн, бичгийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор шийдвэрлэнэ.
13	Тэтгэмжийн доод хэмжээ	Нийлмийн даатгалын тэтгэвэр хөдөлгөөн, бичгийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор шийдвэрлэнэ. -Хөдөлмөрийн чадвараа 10 хүртэл хувиар авсан бол ХХД-ий 10 хувь, -Хөдөлмөрийн чадвараа 30 хувь хүртэл авсан ажилтанд 5 сарын цалингийн дундажтай тэнцэх хэмжээний нөхөн төлбөрийг нэг ба түүнээс дээш удаа олгоно.	7 хоногийн дундаж цалингийн 60%-ийг	Сүүлийн 3 сарын цалингийн дундажийг 53 өдрөөр /гэмтлийн зэрэг/ болж олгоно. -80,000 ленийг ЗГ-аас /нэг удаагийн мөнгөн тэтгэмж/	Тухайн ажилчны дундаж цалинд үндэслэн тоолох олгоцоо салбар болон даатгалын төрлөөс янз бүр шалтгаалж тогтоогдог.	Гэмтлийн зэрэг 14-24% бол хөдөлмөрийн хөдөлгөөн, бичгийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор шийдвэрлэнэ.
14	Амь насаа алдсан тохиолдолд	Тэтгэвэр тэтгэвэр хөдөлгөөн, бичгийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор шийдвэрлэнэ. -Хөдөлмөрийн чадвараа 10 хүртэл хувиар авсан бол ХХД-ий 10 хувь, -Хөдөлмөрийн чадвараа 30 хувь хүртэл авсан ажилтанд 5 сарын цалингийн дундажтай тэнцэх хэмжээний нөхөн төлбөрийг нэг ба түүнээс дээш удаа олгоно.	Оршуулгын зардал, нас барсны тэтгэмжийг үлсн дундаж цалин, түүнтэй адилтгах орлогоос хувь хэмжээгээр тогтоно.	Нөхөн олговрын хэмжээг өдрүүлээр болох олгодог. Түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн тооноос хамрааранг /ЗГ-аас бас 120 өдрийн цалинд оршуулын зардалд зориулж олгоно.	Үйлдвэрлэлийн ослор амь насаа алдсан тохиолдолд ар гэрт нь нөхөн олговрын хэмжээг тухайн ажилчны нэг өдөр ажиллах өдрийн ажлын хөлсийг 1300 өдрөөр дундаж цалингийн дундажтай тэнцэх хэмжээний нөхөн олговроос гадна бас 120 өдрийн цалинд оршуулын зардалд зориулж олгоно.	Гэмтлийн зэрэг 14-24% бол хөдөлмөрийн хөдөлгөөн, бичгийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор шийдвэрлэнэ.



Монгол Улсад “Хөдөлмөрийн тухай”, Нийгмийн даатгалын багц хууль тэр тусмаа “Нийгмийн даатгалын сангаас үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр тэтгэмж төлбөрийн тухай” зэрэг хуулиар ҮО, МШӨ-ий тэтгэвэр тэтгэмж /нөхөн төлбөр/-тэй холбогдох харилцааг зохицуулдагыг бид дээр дурьдсан билээ.

ҮОМШӨ-ний даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэр авагчдын талаар НДЕГ-ын мэдээллийн сангаас үзэхэд: 2012 оны байдлаар ҮОМШӨ-ний даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэр авч буй нийт 5438 иргэдийн 1346 нь буюу 24.7 хувь нь үйлдвэрлэлийн ослоор тэтгэвэр авч байгаа бол, 4093 нь буюу 75.3 хувь нь мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас тахир дутуугийн тэтгэвэр авч байна.

Хүснэгт 4. ҮОМШӨ-ний даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэр авагчид

д/д	Он	Нийт тахир дутуугийн тэтгэвэр авч буй хүний тоо	ҮО-оор тэтгэвэр авч буй хүн		МШӨ-нөөр тэтгэвэр авч буй хүн	
			Тоо	Хувь	Тоо	Хувь
1	1995 оноос өмнө	1060	426	31.6	634	15.5
2	1995-2004	2676	426	31.6	2250	55.0
3	2005-2009	1431	340	25.2	1091	26.7
4	2010-2012	271	154	11.4	117	2.8
	Нийт дүн	5438	1346	100	4092	100

Тус сангаас тэтгэвэр авч буй нийт хүмүүсийн 19.5 хувь нь 1995 оноос өмнө, 49.2 хувь нь 1995-2004 онд, 26.3 хувь нь 2005-2009 онд, 5 хувь нь 2010-2012 онд тус тус тэтгэвэр тэтгэмж тогтоолгосон байна. Нийт тэтгэвэр авагчдын 75,5 хувь буюу 4107 нь 1995-2009 онд тэтгэвэр тогтоолгосон байна. 1995-2009 онд жилд дунджаар 274 иргэн шинээр тэтгэвэр тогтоолгож байжээ.

2010-2012 онд 271 иргэн тахир дутуугийн тэтгэвэр тогтоолгосон нь нийт тэтгэвэр авагчдын 5 хувийг эзэлж байна. 2010-2012 онд жилд дунджаар 90 орчим иргэн шинээр тэтгэвэр тогтоолгосон нь 1995-2009 онд тогтоолгож байсан тэтгэвэр авагчдын дунджаас 3 дахин багасчээ. Тус сангаас тахир дутуугийн тэтгэвэр авагчдыг хүйсийн хувьд авч үзвэл: 5438 тэтгэвэр авагчийн 3994 буюу 73.4 хувь нь эрэгтэй, 1444 буюу 26.6 хувь нь эмэгтэй байна. 2005-2012 онуудад ҮО-оор тэтгэвэр авч буй нийт 494 хүн байсан бол тус онуудад нийт 2791 хүн хүнд болон хөнгөн хэлбэрийн үйлдвэрлэлийн осолд өртснийг дээр дурьдсан билээ. Энэ үзүүлэлтээс харахад осолд орсон гэж бүртгэгдсэн хүний тооноос үйлдвэрлэлийн ослоос болж тэтгэвэр /нөхөн төлбөр/ авч буй хүмүүс 5,6



дахин бага байна. Үүнд мэргэжлийн бус ажилтнууд тогтвор суурьшилтай ажилладаггүй, хууль эрх зүйн хүрээн дэх баримт бичгийн бүрдүүлэлт хангалтгүй, тэтгэвэр авах тогтолцооны шат дамжлагаас ажилтан шантрах, үйлчилгээний чанар, хүртээмж хангалтгүй гэх мэт судлагдсан болон судлагдаагүй олон хүчин зүйл нөлөөлж байна.

Зураг 14. Ажилчдын үйлдвэрлэлийн ослын нөхөн төлбөр шинээр авагчдын тоо, оноор /Япон/ (Хэмжих нэгж: Тоо)



Япон Улсын хувьд жил тутам шинээр ҮО-ын нөхөн төлбөр авагчдын тоог гаргасаныг харвал жил ирэх тусам энэ тоо буурах хандлагатай байна. Үүнийг өөрийн улстай харьцуулбал манай улсын хувьд 2005-2009 онуудад нийт 340 хүн бөгөөд жилд дунджаар 68 хүн ҮО-оор тэтгэвэр авч байгаа бол Японд тус онуудад нийт 2,678,275 хүн ҮО-ын нөхөн төлбөр авсан байна. Нөхөн төлбөр авагчдыг хөдөлмөр эрхэлж буй хүний тоонд харьцуулбал Японд 0,9 хувь, Монголд 0,007 хувь байна. Энэ нь Япон Улсын хувьд нөхөн төлбөр авагчдын тоогоор Монголоос хэд дахин их байгаа нь харагдаж байна. Гэвч энэ тоо бол тийм ч баттай эх сурвалж болж чадахгүй юм. Учир нь Монгол Улсын хувьд жилд ҮО-ын тэтгэвэр авагчдын тоог дундажлан гаргасан. Мөн түүнчлэн Япон Улсын хувьд нөхөн төлбөрийн тогтолцоо харьцангуй боловсронгуй, иргэдийн хандлага, мэдлэг зөв байж болох юм.

2012 оны байдлаар ҮОМШӨ-ний даатгалын сангаас тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагчдын талаар НДЕГ-ын мэдээллийн сангаас харвал: ҮОМШӨ-ний даатгалын сангаас тэжээгчээ алдсаны тэтгэвэр авч буй 686 тэтгэвэр авагчийн 385 нь буюу 56.1 хувь нь үйлдвэрлэлийн ослоор, 301 нь буюу 43.9 хувь нь мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас нас барсан даатгуулагчид байна. Тус сангаас тэтгэвэр авч буй нийт хүмүүсийн 13.0



хувь /89/ нь 1995 оноос өмнө, 27.4 хувь /188/ нь 1995-2004 онд, 33.1 хувь /227/ нь 2005-2009 онд, 26.5 хувь /182/ нь 2010-2012 онд тус тус тогтоогдсон байна. Нийт тэжээгчээ алдсаны тэтгэврийн 60.5 хувь буюу 415 нь 1995-2009 онд тэтгэвэр тогтоолгосон бөгөөд үүний 56.1 хувь буюу 233 нь Үйлдвэрлэлийн ослоор амь насаа алдсан даатгуулагчийн ар гэрт тогтоон олгосон тэтгэвэр байна. Тус онуудад үйлдвэрлэлийн ослоос болж амь насаа алдсан хүний тоо 974 байсныг өмнөх бүлэгт дурьдсан. Үүнээс харахад ослоос болж амь насаа алдсан хүний бүртгэгдсэн тооноос тэтгэвэр авч байгаа хүний тоо 4,18 дахин бага байна. Үүний шалтгаан нь мэргэжлийн бус ажилтнууд тогтвор суурьшилтай ажилладаггүй, хууль эрх зүйн хүрэн дэх баримт бичгийн бүрдүүлэлт хангалтгүй, тэтгэвэр авах тогтолцооны шат дамжлагаас ажилтны ар гэрийн гишүүд шантрах, үйлчилгээний чанар, хүртээмж хангалтгүй гэх мэт судлагдсан болон судлагдаагүй олон хүчин зүйл байж болох юм.

Харин 1995-2009 онд жилд дунджаар 15 иргэн үйлдвэрлэлийн ослын улмаас нас барж ар гэрт нь тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоогдож байсан бол 2010-2012 онд жилд дунджаар 31 иргэн нас барж тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгосон байна.

Тус сангаас нийт тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагчдыг хүйсийн хувьд авч үзвэл: 686 тэтгэвэр авагчийн 114 буюу 31.7 хувь нь эрэгтэй, 571 буюу 83.3 хувь нь эмэгтэй байна.



ДҮГНЭЛТ

Монгол Улсын хувьд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар хууль эрх зүйн орчин бүрдсэн гэж дүгнэж болох хэдий ч “Нүүрсний салбарын ХАБЭА-н төлөв байдлын судалгаа”-аар ХАБЭА-н дүрэм, журам батлагдсан цагаасаа хойш сайжруулалт хийгдээгүй, орчин үеийн техник, технологийн онцлог, хүчин чадалд нийцэхгүй, хоцрогдсон, ХАБЭА-н 130 гаруй нийтлэг стандарт байгаа боловч 97 хувьд стандартыг боловсронгуй болгох, техник хэрэгсэлтэй харьцах, ослоос сэргийлэх хандлагыг өөрчлөх, ХАБЭА-н ажлын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах шаардлагатай байгаа дүгнэлт гарсан байдаг. “Хамтын гэрээ, хамтын хэлэлцээрийн төлөв байдал, хэрэгжилтийн судалгаа”-нд Сүүлийн 2 жилийн хугацаанд ХХ, МШӨ, Үйлдвэрлэлийн осол гарч байсан эсэхийг ажил олгогчоос тодруулахад ААНБ-ын ажиллагчдын тооны бүлэг буюу ААНБ-ын үйл ажиллагаа өргөжин тэлж, томрох тусам тохиолдлын тооны хувь ихэсч байсан байна.

Үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх асуудлыг ХАБЭА-н тухай хууль, ҮО, МШӨ, ХХ-ыг судлан бүртгэх дүрмээр зохицуулдаг ч манай орны хувьд бусад орнуудтай харьцуулахад судалж, бүртгэх, мэдээлэх асуудал учир дутагдалтай байсаар байна. Бид Монгол Улсад үйлдвэрлэлийн ослын бүртгэгдсэн тохиолдлын тоо, осолд орсон хүний тоо, ҮО-ын нөхөн төлбөрийн асуудлыг бусад орнуудтай харьцуулан үнэлэлт дүгнэлт өгөхийг хичээсэн. ҮО-ын тоон мэдээлэл нь төдийлөн хангалттай бус юм. Үйлдвэрлэлийн ослын тоог маш олон үзүүлэлтүүдээр харуулахыг зорьсон ба тохиолдлын тоо цаг хугацааны хувьд буурах хандлагатай байгаа хэдий ч үйлдвэрлэлийн ослоос болж амь насаа алдсан хүний тоо төдийлөн буурахгүй байна. ЭЗҮА-ы салбаруудаар авч үзвэл ХАА-н салбарт тохиолдох үйлдвэрлэлийн ослын тоо харьцангуй бага, уул уурхай, барилгын салбарын хувьд ҮО-ын тоо сүүлийн долоон жилийн байдлаар ямагт өндөр байна. Харин Япон Улсын үйлдвэрлэлийн ослын тоог харвал /2010 он/ боловсруулах аж үйлдвэрийн салбар, барилгын салбарт үйлдвэрлэлийн осол их тохиолдож байсан бол манай улсын хувьд уул уурхай, барилгын салбарт илүү тохиолдож байна. Үйлдвэрлэлийн ослоос болж амь насаа алдсан хүмүүсийн тоог харьцуулбал Монгол Улс нийт амь насаа алдсан хүмүүсийн тоогоор маш бага харагдаж байгаа хэдий ч хөдөлмөр эрхэлж буй хүмүүст эзлэх хувиар авч үзвэл Япон Улсаас бага зэрэг өндөр байна. Үйлдвэрлэлийн ослоос болж амь насаа алдсан хүмүүсийн тоог салбараар харахад мөн л барилга, уул уурхайн салбар давамгайлж байна. Үйлдвэрлэлийн ослын шалтгааныг сүүлийн арван



жилийн байдлаар авч үзвэл 2004, 2006, 2008-2010 онуудад ослын гол шалтгаан уналт, нуралт байсан бол зарим онуудад бусад шалтгаанууд өндөр хувийг эзэлж байна. Мөн аюулгүй ажиллах арга барилд хангалтгүй суралцснаас осол гарах үндсэн шалтгаан болж байна. ҮО-д орсон хүмүүсийг ажлын туршлагаар авч үзэхэд 2004, 2005 онд 5 хүртэл жил ажилласан хүмүүс осолд бага өртөж байсан бол 2006 оноос хойш ихсэх хандлагатай байна. Мөн нийт ҮО-д өртөгсдийг насны бүлгээр авч үзэхэд 18-35 насны ажиллагчид осолд орох нь 2005 оноос хойш нэмэгдэх хандлагатай байна. 18 нас хүртэлх насны ажиллагчид ҮО-д харьцангуй бага өртсөн байгаа нь тухайн насны ажиллагчид нийт хөдөлмөр эрхлэгчдийн дотор бага хувийг эзэлж байгаатай холбоотой.

Манай улсын хувьд “Хөдөлмөрийн тухай”, “Нийгмийн даатгалын сангаас үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр тэтгэмж төлбөрийн тухай” зэрэг хуулиуд болон бусад холбогдох дүрэм, журам, заавраар ҮО-ын нөхөн төлбөр, түүнтэй холбогдох бүхий л харилцааг зохицуулдаг.

Монгол Улсын ҮО-ын нөхөн төлбөрийн талаар бусад орнуудтай харьцуулахад Япон, Хятад улсуудтай тогтолцооны зарим үзүүлэлтээр ойролцоо хэдий ч нөхөн төлбөрийн хэмжээ, бодох аргачлал зэргээр ялгаатай талууд байна. Үйлдвэрлэлийн ослын даатгалын тогтолцооны зохион байгуулалтын хувьд манай улс салангид, бодлогын хувьд нэгдмэл бус /тус тусдаа чиглэлийн яамдад/байгаа бол бусад орнуудын хувьд нэгдмэл, нэг газарт төвлөрүүлсэн байна. Мөн тэтгэмжийн төрөл хэлбэрээр ойролцоо талууд байгаа ч бусад орнуудаас Солонгос, Австрали, Англи зэрэг орнуудад асран хамгаалах/асрагчийн/, мэргэжлийн нөхөн сэргээх үйлчилгээ, түргэн тусламжийн үйлчилгээ, мэргэжлээрээ дахин боловсрох, сургалтанд хамрагдах, ажлын тусламж, тоног төхөөрөмжөөр хангагдах зэрэг нөхөн төлбөрүүдийг даатгалын байгууллагаасаа авч болдог байна. ҮО-ын нөхөн төлбөрийн эх үүсвэрийн хувьд Монгол улс нь ажил олгогчийн төлөх шимтгэл буюу хураамж /даатгуулагч/, ААНБ-аас /даатгуулсан эсэхийг үл хамааран хөдөлмөрийн хуулийн 97-р зүйл/ бүрдэж байна. Харин Хятад, Англи, Австрали улсуудын хувьд зөвхөн ажил олгогчийн төлөх хураамж /даатгуулагч/-аас бүрддэг бол Япон, Солонгос улсын хувьд ажил олгогчийн төлөх хураамж /даатгуулагч/-аас гадна даатгуулсан эсэхээс үл хамааран засгийн газраас нэг удаагийн тэтгэмж өгдөг байна. ҮО-ын нөхөн төлбөрийг нэхэмжлэх, гомдол барагдуулах хугацаа улс орон бүрт харилцан адилгүй өөр өөр байна.



НДЕГ-ын тоон мэдээллээс харахад үйлдвэрлэлийн ослын улмаас хохирч тахир дутуугийн тэтгэмж болон тэжээгчээ алдсаны тэтгэмж авч байгаа хүний тоо тухайн онуудад үйлдвэрлэлийн осолд өртсөн болон ослоос болж амь насаа алдсан хүмүүсийн тооноос хэд дахин бага байна. Үүнд мэргэжлийн бус ажилтнууд тогтвор суурьшилтай ажилладаггүй, хууль эрх зүйн хүрээн дэх баримт бичгийн бүрдүүлэлт хангалтгүй, тэтгэвэр авах тогтолцооны шат дамжлагаас ажилтан шантрах, үйлчилгээний чанар, хүртээмж хангалтгүй гэх мэт судлагдсан болон судлагдаагүй олон хүчин зүйл нөлөөлж байна.



САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. Үйлдвэрлэлийн ослын нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох аргачлал, үндэслэл, гэмтлийн зэрэг болгон ангилах тогтолцоог бусад орны туршлагаас судлан :
 - ✓ Гэмтлийн зэрэг тогтоох: Япон, Англи, Австрали улсуудын ҮО-оос үүдсэн бэртэл, гэмтлийг гэмтлийн зэрэг болгон ангилах тогтолцоог судлан Монголын хөрсөнд буулгах, нэвтрүүлэх. /Тухайлбал: Япон Улсад гэмтлийн 14 зэрэг болгон ангилдаг бөгөөд түүнд тохирох өдрийг тухайн ажилтны цалингийн дундажаар бодож олгодог./
 - ✓ Нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох: Гэмтлийн зэрэг тогтоож, улсын хэмжээн дэх салбарын дундаж цалинд үндэслэн ялгавартай тогтоох /Хятад/
2. Үйлдвэрлэлийн ослын талаарх мэдээллийн тогтолцоог нэгдсэн сан бүрдүүлж төвлөрүүлэх:
 - ✓ Осолд өртсөн болон тэтгэвэр тэтгэмж авсан хүмүүсийн дэлгэрэнгүй мэдээллийн сан үүсгэж нэгдсэн төвд байршуулах
 - ✓ Мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэхэд хяналт тавих
 - ✓ Ослын талаар мэдээлэх байдлыг үнэлж дүгнэн, урамшуулах тогтолцоог бий болгох, ААНБ-ын мэдээлэх байдалд хүлээх хариуцлагыг нэмэгдүүлэх
3. Даатгалын тогтолцоог:
 - ✓ Тэтгэвэр тэтгэмжийн төрөл хэлбэрийг боловсронгуй болгож, хуульд нэмэлт өөрчлөлт оруулах /Солонгос, Австрали, Англи улсуудын туршлагыг судлан нөхөн төлбөрийн уян хатан байдлыг нутагшуулах/
 - ✓ ҮО-оос болж амь насаа алдсан тохиолдолд олгох нөхөн төлбөр /тэжээгчээ алдсаны тэтгэмж/-ийн дотоод зохион байгуулалтыг нарийвчлан сайжруулах- Япон улсын тэжээгчээ алдсан тохиолдолд ар гэрт олгох нөхөн төлбөрийн нарийвчилсан тогтолцоог судлах
 - ✓ Нэхэмжлэл гаргах, гомдол барагдуулах хугацааг аль болох хүндээ чиглэсэн уян хатан болгох зэрэг замаар сайжруулах, туршлагыг судлан нэвтрүүлэх



АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. “Хөдөлмөрийн тухай хууль” УБ хот 1999.05.14
2. “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль” 2008.05.22
3. “Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай” УБ хот 1994.06.07
4. “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай” УБ хот 1994.06.07
5. “Нийгмийн даатгалын тухай хууль” УБ хот 1994.05.31
6. “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” Хөдөлмөрийн яам, ШУТИС, Монголын мянганы сорилтын сан /2012/
7. “Хөдөлмөрийн салбарт түгээмэл хэрэглэгддэг нэршил, ойлголт тодорхойлолт” /2014/
8. “Үйлдвэрлэлийн ослын даатгалын нөхөн төлбөрийн тухай хууль” Солонгос улс
9. “Occupational accident insurance for all workers: the new challenges for china”
10. “Australian workers’ compensation”
A Report for the Mobbs’ Travelling Fellowship
11. “Industrial Injuries Disablement Benefits: technical guidance”

Цахим эх сурвалж

- Үндэсний статистикийн хороо, www.1212.mn, www.nso.mn
- Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, www.legalinfo.mn
- www.inspection.gov.mn
- www.ndaatgal.mn
- www.fom.ac.uk/wp-content/uploads/mobrepsi.doc
- www.ilo.org
- www.en.wikipedia.org
- www.hazards.org
- www4.hrsdc.gc.ca
- www.bls.gov
- www.ncbi.nlm.nih.gov
- www.jisha.or.jp
- www.stat.go.jp
- www.korealaw.com
- www.gov.uk



Хавсралт 1. ЭЗҮА Салбаруудын үйлдвэрлэлийн ослын шалтгаан (Хэмжих нэгж: Тоо)

Салбар	Он	Ослын шалтгаан							
		Уналт нуралт	Тээврийн хэрэгслийн эвдрэл гэмтэл	Өргөх механизмийн эвдрэл гэмтэл	Тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтэл	Технологийн процесс зөрчсөн	Аюулгүй ажиллах арга барилд хангалтгүй суралцсан	Ажлын хувцас	Бусад
Эрчим хүч	2008	4	2	0	2	5	4	2	11
	2009	3	3	2	0	2	3	3	1
	2010	6	3	0	2	1	6	2	2
	2011	5	0	0	3	6	1	3	7
	2012	1	1	1	1	5	2	0	3
	2013	4	0	4	2	1	2	1	8
Уул уурхай	2008	32	12	10	12	13	33	2	9
	2009	24	6	4	5	14	17	2	9
	2010	20	11	1	10	17	23	0	12
	2011	20	9	3	4	5	21	2	16
	2012	14	13	4	4	8	31	0	17
	2013	13	3	1	4	3	12	1	23
Хөдөө аж ахуй	2008	0	0	0	0	0	1	0	1
	2009	0	0	0	0	0	1	0	1
	2010	0	1	0	0	1	2	0	0
	2011	0	0	0	0	0	0	0	3
	2012	0	0	0	0	1	0	0	0
	2013	4	0	0	2	3	1	0	2
Барилга	2008	58	3	12	12	19	29	8	8
	2009	28	7	2	2	4	6	1	5
	2010	23	2	3	0	4	9	4	7
	2011	36	2	1	4	7	7	9	6
	2012	37		8	2	5	9	3	8
	2013	20	2	3	1	2	3	1	7
Хөнгөн хүнс	2008	12	0	2	5	15	5	4	21
	2009	4	1	0	6	3	6	2	10
	2010	9	0	0	10	2	7	1	2
	2011	5	3	0	2	5	6	4	4
	2012	5	1	1	2	4	7	1	5
	2013	4	4	0	2	2	11	0	9
Зам тээвэр холбоо	2008	17	8	6	2	5	6	0	13
	2009	6	29	2	0	0	6	0	11
	2010	7	2	1	2	3	9	0	9
	2011	3	13	0	0	1	8	0	25
	2012	4	4	1	0	1	3	0	24
	2013	8	17	1	4	0	1	0	16
Худалдаа үйлчилгээ	2008	15	4	1	5	1	18	0	3
	2009	4	0	0	1	2	0	0	5
	2010	7	2	0	0	1	0	0	5
	2011	2	4	0	1	0	4	0	5
	2012	6	1	0	1	2	0	0	8
	2013	7	4	0	1	0	1	0	6



Боловсрол	2008	12	5	0	0	0	4	0	16
	2009	14	2	0	0	0	3	0	26
	2010	8	1	0	1	1	2	0	9
	2011	8	10	0	0	0	3	1	16
	2012	6	1	0	1	1	0	0	21
2013	6	7	0	2	0	0	1	31	
Эрүүл мэнд	2008	6	7	1	2	1	3	0	12
	2009	9	4	0	1	0	0	0	11
	2010	13	7	0	2	0	6	0	16
	2011	7	5	0	1	0	4	0	11
	2012	8	3	0	0	0	5	0	22
2013	2	7	1	1	0	0	0	21	
Бусад	2008	36	38	3	5	3	21	0	24
	2009	21	32	3	7	4	6	0	14
	2010	19	7	0	5	4	11	1	34
	2011	15	10	0	0	0	10	1	54
	2012	21	6	0	3	1	15	0	53
2013	6	25	2	1	1	11	3	45	